



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2024 оны ээлжит 01 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 01 дүгээр хуралдааныг 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулав.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Орон тооны бус гишүүнийг чөлөөлөх тухай” 210 тоот захирамжаар Харилцаа холбооны тухай хуулийн 8.3-т заасныг үндэслэн Өлзийбаяр овогтой Золбаярыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээс чөлөөлсөн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2023 оны 155 тоот тогтоол: “ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт); “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт” зарлах тухай; Хорооны хуралдааны удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэх тухай (Тэмдэглэлийн төсөл) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 12 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр (Тогтоол №01-12, Хуралдааны тэмдэглэл-№01, 2024-01-11) хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.

Аливаа ажил олгогч нь нийт ажилтан алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй. ХХЗХ-ны эзэмшлийн байранд буюу 2023 оны 12 дугаар сарын 28-ны өглөөний 6 цаг орчимд Метро бизнес төвийн 7-р давхарт үйл ажиллагаа явуулдаг “Хөгжлийн шүтэлцээ” ТББ-ын ариун цэврийн өрөөний цэвэр усны шугамын гэмтлийн улмаас 6 болон 5 давхарт ус их хэмжээгээр алдсан. 5 дугаар давхарт ус алдаж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон гэж үзэн байгууллагын үйл ажиллагааг яаралтай зогсоож, нөхцөл байдлыг арилгах арга хэмжээг хугацаа алдалгүй авч ажилласан. Хорооны даргын А/354 тоот тушаалаар хариуцлагатай жижүүр томилогдон 2023 оны 12 дугаар сарын 29, 30, 31, 2024.01.01-ний өдрүүдэд усыг шавхаж цэвэрлэсэн ба хорооны удирдлагууд, ХАБЭА хариуцсан ажилтан тухай бүр ирж нөхцөл байдалтай танилцаж ажилласан. Учирсан хохирол: ЗУХАГ-ын Санхүүгийн хэлтсийн өрөөний тааз, хана, шал; ЗУХАГ-ын хамтын ажиллагааны хэлтсийн өрөөний тааз, хана, шал; ЗУХАГ-ын тусгай зөвшөөрлийн архив болон ажилчдын өрөөний тааз, хана, шал; Захиргааны угтах үйлчилгээний ажилчдын өрөөний тааз, шал; Уулзалтын өрөөний тааз, коридорын тааз; ӨНЗГ-ын 2 өрөөний тааз; Ажилтан албан хаагчдын 1ш зөөврийн, 2ш суурин компьютер болон нийтийн хэвлэгч машины дээрээс ус гоожсон ба тус тус засвар, үйлчилгээ хийх шаардлагатай байна.

байранд учирсан нийт хохирлыг тогтоох зорилгоор Бодит үнэлгээ ХХК-иар үнэлгээг хийлгүүлсэн ба хохирлын нийт дүн 45,024,357 төгрөг гэж тогтоосон болно.

Иймээс холбогдох ажлын хэсэг, ЗУХАГ-аас боловсруулсан танилцуулга, хохирлын үнэлгээний дүгнэлт, шаардлагатай хөрөнгийн тооцоо судалгаа, тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг тус тус хэлэлцүүлэв. Энэхүү асуудлаар, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолын хавсралтаар батлагдаж, 2020 оны 67 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 12 тоот “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг баталж, хорооны 2023 оны 155 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, зардлын төлөвлөгөө”-нд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан батлав. Энэхүү тогтоолд, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 155 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал”-д Хорооны төв оффисын 5 давхрын өрөө тасалгаа, коридорт үүссэн гэнэтийн эвдрэл гэмтлийг арилгах, ажилтнуудын эрүүл байх, ажиллах хэвийн нөхцөлийг хангах, сэргээхтэй холбоотой барилгын засварыг хийх; Хорооны төв оффисын цахилгааны холболтын суурь засвар хийх, цахилгааны болон галын аюулгүй байдлын найдвартай ажиллагааг хангах зорилгоор холбогдох зардлыг тусган баталсан болно.

ХХЗХ-ны 2024 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 10 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 10 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2024

оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 04 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг (Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 07 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 08 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд (Ноён Уул радио НҮТББ) өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт Уэст глобал ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 09 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 10 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар (Доктор авто чэйн ХХК) шинээр олгож тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2024-01-17